

БАСАРХАН ЦЭЦЭРЛЭГИЙН 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН

ЖИЛИЙН ЭЛСЭЛТ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Басархан” цэцэрлэгт 2022-2023 оны хичээлийн жилд элсэн суралцагч, байгууллагын хүүхдийн суудлын асуудлыг зохицуулахад оршино.

Хоёр. Элсэгчид тавигдах шаардлага

2.1 Бага бүлэгт шинээр элсэн суралцагч нь 2022 оны 12 сарын 31 гэхэд 2 нас бүтэн хүрсэн байх шаардлагатай.

2.2 Цэцэрлэгт орох хүүхдийг биеэр авч ирэн ярилцлагад хамрагдана.

Гурав. Шинээр элсэн орох, дэвшин суралцах тухай

Шинээр элсэгч болон дэвшин суралцагчийг дараах алхмаар бүртгэж цэцэрлэгт элсүүлж, мөн бүлэг дэвшүүлэн суралцуулна. Үүнд:

3.1. Эцэг эхийн гэрээтэй танилцаж цахим бүртгэлээр анкет бөглөх

Шинээр элсэн суралцагч болон дэвшин суралцагч нь жил бүрийн 08 сарын 1-ний өдрөөс 08 сарын 15-ны өдрийн хооронд цэцэрлэгийн албан ёсны “Басархан цэцэрлэг” фэйсбүүк хуудсанд зарласан цахим бүртгэлийн линк болон цэцэрлэгийн фэйсбүүк хуудасны захидал /чат/ хэсэгт байршуулсан элсэлтийн цахим бүртгэлийн линкээр орж бүртгүүлнэ.

3.2. Урьдчилгаа 9-р сарын төлбөрийг бүтэн, 1-р сарын сарын төлбөрийн 50% ийг төлснөөр элсэлтээ баталгаажуулах

Дээрх хугацаанд суудлаа баталгаажуулаагүй тохиолдолд бүртгүүлэхээс татгалзсанд тооцож дараагийн элсэгчийг бүртгэнэ.

3.3. Гэрээг биечлэн байгуулах, бүртгүүлэх

Гэрээтэй танилцаж хүлээн зөвшөөрч төлбөрөөр баталгаажсан эцэг эх, асран хамгаалагч нь тухайн жилийн 08.15-ний өдрөөс 08.25-ний өдрүүдэд БАСАРХАН цэцэрлэгт өөрийн биеэр ирж гэрээг бичгээр байгуулж, хүүхдийн дэлгэрэнгүй анкетыг бөглөнө. Гэрээ байгуулахаар ирэхдээ дараахи бичиг баримтыг авч ирнэ.

- Хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар
- Хүүхдийн 2 хувь цээж зураг

Төлбөр цэцэрлэгийн дансанд орсон эсэхийг лавлахыг хүсвэл 99799383 дугаарт зөвхөн мессеж илгээж лавлана уу.

Дөрөв: Хичээлийн шинэ жилд бэлтгэх

4.1 Гэрээ хийсний дараа хүүхдийн хувийн хэрэгцээнд шаардлагатай зүйлсийн жагсаалтын дагуу материалыг бэлтгэж 8 дугаар сарын 31 ний өдрийн дотор хариуцсан бүлгийн багш нарт хүлээлгэн өгнө.

БАСАРХАН ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАХИРГАА